

## 4. Удирдамж

Асуулгын удирдамж 2023.09.19



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, Г  
индекс шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексийг 2022-2023 оны хичээлийн жилийн элсэлтээс эхлэн мөрдсүгэй.
3. Дээд боловсролын сургалтын байгууллагад одоо суралцаж буй суралцагчдыг элссэн мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн дагуу төгсгөхийг их, дээд сургууль, коллежийн захирал нарт үүрэг болгосугай.
4. Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ тушаалын хавсралтад заасан мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексэд нийцүүлэн шинэчлэн олгох, цаашид цахимжуулах арга хэмжээ авахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/-т даалгасугай.
5. Шинэчилсэн мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексийг өмнө мөрдөж байсан эрх зүйн баримт бичигтэй дүйцүүлэх, гадаадад төгссөн оюутны мэргэжил хөтөлбөрийг дүйцүүлэн ойлгох жагсаалт, аргачлал боловсруулж ажиллахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/-т даалгасугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Г.Ням-Очир/-т тус тус даалгасугай.
7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т даалгасугай.
8. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаал, А/370 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт,

142210614

